

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 13.100.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага	MNS 5078:202X
Occupational safety and health. Occupational hygiene. General requirements for ventilation and casement window of industrial enterprise	MNS 5078:2001-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

1.1

Энэхүү стандарт нь үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлагыг тогтооход хамаарна.

1.2

Стандарт нь газар доорх болон ил уурхай, тэсрэх шатамхай бодис хадгалдаг байр, түр барилгад хамаарахгүй.

2 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

БН 271-79 Үйлдвэрийн газрын агааржуулах төхөөрөмжийн туршилт, тохируулга ашиглалтын заавар

БН 4-70 Үйлдвэрийн барилга төлөвлөлтийн эрүүл ахуйн норм

БН бД 40-06-16 “Дотор сантехникийн систем”

3 Техникийн ерөнхий шаардлага

3.1

Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд (агаарын механик болон ердийн сэлгэлт, агаарын халаалт, агаарын өгөлт болон соролт, агаарын хөшиг, аваарын салхивч) үйлдвэрлэлийн технологийн горимын дагуу зураг төсөлд заасан техникийн шийдлийн дагуу ашиглалтын өмнө туршилт тохируулга хийгдсэн тухай паспорт хөтлөгдсөн байна.

3.2

Агаар дамжуулах хоолой, сэнс (вентилятор), агаар халаагч (калорифер), агааржуулагч (кондиционер), түүний иж бүрдлүүд (блокууд), сэнсний өрөө (вент

камер), түүний эд ангиуд, шүүлтүүр, зөөлөн холбоо, доргио намсгагч, хавхлаг (клапан) агаар сорогч (дефлекфор), агаарын хольц тунгаагч (циклон) гэх мэт тоног төхөөрөмжийг зураг төслийн дагуу угсарсан, угсралтын чанар эд анги, хоолойн холболт, эмжээр нугалалт, жийргэвч, дулаалга, бэхэлгээ зэрэг нь зориулалтын материалаар хийгдэж техникийн шаардлага хангасан байна.

3.3

Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам сүлжээ, удирдах самбар, хэмжилт хяналтын хэрэгсэл, ба газардуулгын тоноглолын иж бүрдүүлэлт, угсралтын болон, ашиглалтын зааврыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж акт үйлдсэн байна.

3.4

Салхивч, агааржуулалтын системийн агаар дамжуулах хоолойн бэхэлгээ нь найдвартай, доргион үүсгэхгүй доргион дамжуулдаггүй байна.

3.5

Ажлын байрнаас бохир агаар сорох хэсгийг технологийн тоног төхөөрөмжийн хөдөлгөөнгүй хэсэгтэй залгасан байна.

3.6

Салхивч, агааржуулалтын системийн агаар дамжуулах хоолойн хавсарга тав (фланц) холболтын жийргэвч хийц, материалыг сонгохдоо тухайн орчны физик, хими, механик шинж чанар, дулаан дамжуулах чадварыг харгалзана.

3.7

Агаар дамжуулах хоолойн залгаа хэсгээр агаар алдагдахаас хамгаалан түүнийг барилгын хана, уулзвар, шавардлага дотор байрлуулж болохгүй.

3.8

Үйлдвэрийн агаар зайлуулах системээр зайлуулагдаж байгаа тоос, хортой ба эвгүй үнэртэй бодис агуулсан агаарыг гадагш хаяхын өмнө Улсын барилгын хорооны (хуучин нэрээр) БН 6 Д 2.09.12-87-д заасны дагуу цэвэрлэнэ.

3.9

Үйлдвэрийн байрны хорт бодис, тоос холилдож хорт хольц буюу химийн нэгдэл үүсгэхээр бол таталтыг нэг системд хамт холбож болохгүй.

3.10

Хортой хий дамжуулдаг агааржуулах системийг ашиглахдаа агаар цэвэрлэх болон дамжуулах төхөөрөмжийн хананы зузаанд жилд 1-ээс доошгүй удаа үзлэг хийнэ.

3.11

Агааржуулах тоног төхөөрөмж суурилсан өрөө цоожтой байх ба хаалган дээр нь гадны хүн орохыг хориглосон анхааруулга бичиж хадсан байна.

3.12

Агааржуулах тоног төхөөрөмж суурилуулсан өрөө нь агаар солилцох, засвар угсралтын ажил, ажиглалт хийх боломжтой, салхивч, агааржуулалтын системийн угсралтын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

3.13

Үйлдвэрийн агааржуулах систем нь техник тоног төхөөрөмжид засвар хийх, угсрах,

ашиглах үед саад болохгүйгээр байрласан байна.

3.14

Үйлдвэрийн барилгын агаар оруулах гаргах системийг ажиллуулах цагийн хуваарийг технологийн онцлогоос хамааруулан тухайн байгууллага гарган мөрдүүлнэ. Салхивч агааржуулалтын системийг ажиллуулах товчлуур, автомат удирдлага нь ажил гүйцэтгэгчийн өрөөнд аль болох ойр байрласан байна.

3.15

Ашиглаж байгаа агааржуулах төхөөрөмж нь техникийн талаар ямар ч гэмтэлгүй бүрэн бүтэн байна. Ашиглалтын явцад төхөөрөмжүүдийн ашиглах хугацааг уртасгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

3.16

Үйлдвэрийн технологийн процесс өөрчилсөн, үйлдвэрлэлийн байрны агаарт хортой бодис ялгаруулдаг технологийн төхөөрөмж ажиллахгүй болсон үед агааржуулах төхөөрөмжийн ажиллагааны горимыг тухайн нөхцөлд тохируулан өөрчилж байвал зохино.

3.17

Үйлдвэрлэлийн агааржуулах системийн ажиллагаа нь гал гарсан үед дэлбэрэлт, галын идэвхийг ихэсгэхгүй, дэлгэрэлт галын эрсдэлийг залгаа өрөө байранд дамжуулахгүйгээр угсарч зохион байгуулсан байна. Үйлдвэрийн галын аюултай ангилалт багтдаг үйлдвэрийн байрны агаар гаргах системийн агаар дамжуулах хоолой, сэнсийг (вентилятор) оч үсэрдэггүй материалаар хийсэн байна.

3.18

Үйлдвэрийн байранд гал гарсан үед ажиллах төлөвлөгөөний дагуу агааржуулах системийн ажиллагааг яаралтай зогсоох, унтраах төхөөрөмжүүдийг урьдчилан төлөвлөсөн байна. Энэ гүйцэтгэх төхөөрөмж нь үйлдвэрийн байрнаас тусдаа байрласан байна.

3.19

Хортой, халуун, хий, уур алдагдаж болох барилгад гал түймэр гарсан үед утааны эсрэг аваарын салхивчийн системийг төсөвлөх шаардлагатай.

4 Хориглох зүйл

4.1

Шатамхай шингэн дамжуулагч хоолой нь агаар дамжуулагч хоолойтой зэрэгцээ байрлаж болохгүй бөгөөд эдгээр хоолойг хооронд нь бэхлэхийг хориглоно.

4.2

Агаарын хоолойгоор 70⁰C-ээс их температуртай агаарыг дамжуулах нөхцөлд хоолойн дотор талыг шалд шатамхай, тэсвэргүй будгаар будахыг хориглоно.

4.3

Агаар сэлгэлтийн өрөөнд шатамхай болон галын аюултай материал бүтээгдэхүүн хадгалах болон бусад хэлбэрээр ашиглахыг хориглоно.

4.4

Угсрагдсан салхивч агааржуулалтын системийг зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өргөтгөх, өөрчлөлт хийхийг хориглоно.